



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулж, дүрэм  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд ажилтан, албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих, сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлыг тогтоож тайлагнах чиг үүрэг бүхий Байгууллагын ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга

Менежер

Гишүүн

Ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга

Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан

2. "Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ-ын захирлын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Ёс зүйн дүрэм батлах тухай" А/54 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг менежер (Б.Зоригоо)-т үүрэг болгосугай.



ЗАХИРАЛ

Г.МӨНХЗУЛ

3130600052